



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 1/33

Дэлгэрхаан сум

Бог малын хээлтүүлэгчид үзлэг  
ангилалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалт хийх, ашиг шимийг тогтоох, ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохин байгуулсугай.

2.Мал сүрэгт үзлэг, ангилалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Батнасан

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Бүжинлхам

(Долоод багийн Засаг дарга)

Г.Батнасан

(Баянхаан багийн Засаг дарга)

Г.Сандаг

(“Мөнх шим өгөөж” хязгаарлагдмал хувьцаат компаний захирал)

Нарийн бичиг дарга: С.Цэцэгсайхан

(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

3. Бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг технологит хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулан заасан хугацаанд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Батнасан), нарийн бичгийн дарга гишүүдэд даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо)-д даалгасугай.

ДАРГА Б.ЭНХ-АМГАЛАН



2326910961